



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр мал нядалгааны цэг барихад 9557.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2017.07.20-ний өдөр иргэн Н.Цэрэнбаттай 9557.8 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байхад гүйцэтгэлээр 12.2 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дэх “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон” гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**



1. Гэрээний дүнгээс илүү олгосон 12,2 мянган төгрөгийг /Арван хоёр мянга хоёр зуун/ төгрөгийг иргэн н.Цэрэнбатаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь

2518039

бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 04 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг дарга Р.Жамьяндорж, нягтлан бодогч Ч.Эрдмаа нарт хариуцуулав.

**ТОГТООСОН!**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
БҮОА0067 9007423

**АКТ**  
**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
  
Р.ЖАМЬЯНДОРЖ  
НЯГТЯАН БОДОГЧ  
  
Ч.ЭРДМАА

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 81

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн халамж, асрамж үйлчилгээнд батлагдсан 1000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, НИК ХХК-д шилжүүлсэн ба зардлыг юунд зарцуулсан нь тодорхой бус, анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.2-т заасан “Сум өөрийн төсвөөр ... сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4-т заасан “Сум ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58.4-т заасан дараахь чиг үүргийг хэрэгжүүлж болно” зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 “Улсад болон

2518043



байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Зориулалтын дагуу зарцуулаагүй 1,000,000 / Нэг сая / төгрөгийг холбогдох буруутай этгээдээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 05 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Ж.Гандалай нарт хариуцуулав.

**ТОГТООСОН!**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
BHO40067 9007423


**АКТ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ

  
Д.МӨНХ-ЭРДЭНЭ

НЯГТЛАН БОДОГЧ

  
Ж.ГАНДАЛАЙ

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 85

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 2017 онд сахилгын шийтгэл ногдуулсан 8 ажилтанд тус бүр 270.0 мянга, нийт 2160,0 мянган төгрөгийг олгосон.

2. Нэмэлт санхүүжилтийн данснаас 2017.11.02-ны өдөр 400.0 мянган төгрөгийг нярав М.Долгорсүрэнгийн дансаар дамжуулан хяналтын зардалд олгосон байхад анхан шатны баримт байхгүй.

3. 2017 оны 07 дугаар сард П.Мөнхтогоогийн 479854 төгрөгийн цалинг Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх “Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ”, 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Ажил олгогч ... хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд

2518053



төлөх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан”... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль, тогтоомж зөрчиж олгосон 2,160,000 /Хоёр сая нэг зуун жаран мянган/ төгрөгийг хавсралтад заасан ажилтнуудаар, анхан шатны баримтгүй олгосон 400,000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийг холбогдох буруутай этгээдээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй орхигдуулсан 478,854 /Дөрвөн зуун далан найман мянга найман зуун тавин дөрвөн/ төгрөгийн цалинг нөхөн мэдээлж, түүнд ногдох НДШ-ийн 100,769 /Нэг зуун мянга долоон зуун жаран есөн/ төгрөгийг Баян-Овоо сумын ЗДТГ-аар төлүүлж, нийгмийн даатгалын сангийн дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 05 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт хариуцуулав.

**ТОГТООСОН<sup>1</sup>:**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
Б-ДА0067 9007423

**АКТ**  
**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
  
М.ЖАВЗАНСҮРЭН  
НЯГТЛАН БОДОГЧ  
  
Б.ҮЛЭМЖСОНИН

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
2018.03.09-ний өдрийн 23-р тоот актын хавсралт

№	Ажилтны нэр	Сахилгын шийтгэл ногдуулсан тушаалын огноо, дугаар	Олгосон урамшууллын дүн	Суутгасан суутгал	Гарт олгосон урамшууллын дүн
1	Д.Эрдэнэбулган	2017.02.01 №06, 2017.06.05 №43	300,000	30,000	270,000
2	Ж.Ганцэцэг	2017.02.01 №06,	300,000	30,000	270,000
3	Б.Үлэмжсонин	2017.02.01 №06, 2017.06.05 №43	300,000	30,000	270,000
4	Л.Алимаа	2017.02.01 №06,	300,000	30,000	270,000
5	О.Бямбажав	2017.02.01 №06, 2017.06.05 №43	300,000	30,000	270,000
6	Ж.Ёндонпил	2017.02.01 №06, 2017.06.05 №43	300,000	30,000	270,000
7	М.Долгорсүрэн	2017.02.01 №06,	300,000	30,000	270,000
8	Б.Отгонбаяр	2017.02.01 №06, 2017.06.05 №43	300,000	30,000	270,000
	ДҮН		2,400,000	240,000	2,160,000